

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сагил сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/97/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2022 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Т.Амармэнд Утас: 70453721, Цахим хаяг: amarmendt@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.29 № УВА-2022/197/НА-СТН-ТМЗ
танай _____-ны № _____-т

САГИЛ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГА Ц.БАТЗАЯА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сагил сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сагил сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.БАТСУУРЬ



0200260427

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,680,000.00</u>	<u>8,850,082.62</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	00.00	00.00
33	АВЛАГА	76,700.00	33,382.62
335	Бусад авлага	76,700.00	33,382.62
3351	Байгууллагаас авах авлага	76,700.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	33,382.62
35	БАРАА МАТЕРИАЛ	7,603,300.00	8,816,700.00
354	Хангамжийн материал	7,603,300.00	8,816,700.00
35410	Бичиг хэргийн материал	259,600.00	496,200.00
35420	Аж ахуйн материал	6,843,700.00	7,820,500.00
35470	Бусад хангамжийн материал	500,000.00	500,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>668,099,412.92</u>	<u>638,679,118.29</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	668,099,412.92	638,679,118.29
392	Биет хөрөнгө	663,497,012.92	634,076,718.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	591,237,000.00	591,237,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-33,784,971.36	-50,677,457.04
39203	Авто-тээврийн хэрэгсэл	16,483,500.00	00.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-16,483,500.00	00.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	65,011,509.00	56,983,195.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-41,069,669.22	-40,014,848.78
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,348,654.80	23,672,376.55
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,189,738.00	-11,855,426.74
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	50,603,800.00	50,603,800.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,259,836.00	13,259,836.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,671,683.30	-7,934,031.70
39217	Ном	8,752,275.00	8,802,275.00
393	Биет бус хөрөнгө	4,602,400.00	4,602,400.00
39303	Бусад биет бус хөрөнгө	4,602,400.00	4,602,400.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	00.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>675,779,412.92</u>	<u>647,529,200.91</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>66,262.62</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	66,262.62
413	Өглөг	00.00	66,262.62
4136	Бусад өглөг	00.00	66,262.62
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	66,262.62
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>675,779,412.92</u>	<u>647,462,938.29</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	675,779,412.92	647,462,938.29
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	92,224,585.00	92,224,585.00
51101	Өмч: - төрийн	92,224,585.00	92,224,585.00
512	Хуримтлагдсан үр дүн	70,310,474.05	43,784,099.42
51210	Өмнөх үеийн үр дүн	70,310,474.05	72,100,574.05
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-28,316,474.63
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	513,244,353.87	511,454,253.87
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>675,779,412.92</u>	<u>647,529,200.91</u>

2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	131,869,140.00	116,089,800.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,615,140.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	34,615,140.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34,615,140.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	463,500.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	34,151,640.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	97,254,000.00	116,089,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	97,254,000.00	116,089,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	97,254,000.00	116,089,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	120,967,750.76	144,199,131.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	120,967,750.76	144,199,131.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	112,178,531.92	116,274,193.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	52,157,613.00	48,531,770.00
210101	Үндсэн цалин	47,117,613.00	43,491,770.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	5,040,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,208,068.16	5,934,392.85
210201	Тэтгэврийн даатгал	4,178,171.07	3,981,483.81
210202	Тэтгэмжийн даатгал	507,474.78	487,726.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	405,957.81	390,924.80
210204	Ажилгүйдлийн даатгал	101,513.96	96,051.96
210205	Эрүүл мэндийн даатгал	1,014,950.54	978,205.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,016,500.00	30,158,000.00
210302	Түлш, халаалт	27,016,500.00	30,158,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,285,700.00	987,000.00
210401	Бичиг хэрэг	276,700.00	364,900.00
210402	Тээвэр, шатахуун	505,800.00	333,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	358,200.00	171,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	145,000.00	117,000.00
210604	Урсгал засвар	1,035,000.00	
2107	Томилолт, зочны зардал	154,000.00	100,000.00
210702	Дотоод албан томилолт	154,000.00	100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	90,000.00	1,299,880.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	1,051,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	216,000.00
210807	Газрын төлбөр	00.00	32,880.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,231,650.76	29,263,151.01
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,231,650.76	29,263,151.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,789,218.84	27,924,937.15

**Сагил сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	17,282,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	17,082,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,489,218.84	10,642,537.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,489,218.84	10,642,537.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>10,901,389.24</u>	<u>-28,109,331.01</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	207,143.62
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	207,143.62
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-207,143.62
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>10,901,389.24</u>	<u>-28,316,474.63</u>

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	97,717,500.00	116,089,800.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	463,500.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	463,500.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	463,500.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	463,500.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	97,254,000.00	116,089,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	97,254,000.00	116,089,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	97,254,000.00	116,089,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	97,717,500.00	116,089,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	97,717,500.00	116,089,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	88,928,281.16	88,164,862.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	52,072,713.00	48,467,368.00
210101	Үндсэн цалин	47,032,713.00	43,427,368.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	5,040,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,208,068.16	5,922,094.85
210201	Тэтгэврийн даатгал	4,178,171.07	3,969,183.81
210202	Тэтгэмжийн даатгал	507,474.78	487,728.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	405,957.81	390,924.80
210204	Ажилгүйдлийн даатгал	101,513.96	96,051.96
210205	Эрүүл мэндийн даатгал	1,014,950.54	978,205.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,016,500.00	30,158,000.00
210302	Түлш, халаалт	27,016,500.00	30,158,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,342,000.00	904,000.00
210401	Бичиг хэрэг	245,000.00	203,900.00
210402	Тээвэр, шатахуун	505,800.00	333,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	358,200.00	171,600.00
210404	Ном, хэвлэл	58,000.00	50,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	175,000.00	145,000.00
2105	Нормативт зардал	500,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,395,000.00	937,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	360,000.00	69,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	80,000.00
210604	Урсгал засвар	1,035,000.00	788,000.00
2107	Томилолт, зочны зардал	154,000.00	100,000.00
210702	Дотоод албан томилолт	154,000.00	100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	240,000.00	1,675,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,000.00	1,459,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	216,000.00

**Сагил сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,789,218.84	27,924,937.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	17,282,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	17,082,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,489,218.84	10,642,537.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,489,218.84	10,642,537.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>00.00</u>	<u>00.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>00.00</u>	<u>00.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	92,224,585.00	513,244,353.87	59,409,084.81	664,878,023.68
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	92,224,585.00	513,244,353.87	59,409,084.81	664,878,023.68
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	10,901,389.24	10,901,389.24
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	92,224,585.00	513,244,353.87	70,310,474.05	675,779,412.92
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	92,224,585.00	513,244,353.87	70,310,474.05	675,779,412.92
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,790,100.00	1,790,100.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	92,224,585.00	513,244,353.87	72,100,574.05	677,569,512.92
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-1,790,100.00	00.00	-1,790,100.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-28,316,474.63	-28,316,474.63
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	92,224,585.00	511,454,253.87	43,784,099.42	647,462,938.29

2.6. АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	116,089,800.00	105,447,262.85	10,642,537.15	90.8%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	116,089,800.00	105,447,262.85	10,642,537.15	90.8%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	98,757,400.00	88,164,862.85	10,592,537.15	89.3%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	56,427,600.00	48,467,368.00	7,960,232.00	85.9%
210101	Үндсэн цалин	51,387,600.00	43,427,368.00	7,960,232.00	84.5%
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	5,040,000.00	0.00	100.0%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,617,800.00	5,922,094.85	1,695,705.15	77.7%
210201	Тэтгэврийн даатгал	5,360,600.00	3,969,183.81	1,391,416.19	74.0%
210202	Тэтгэмжийн даатгал	564,300.00	487,728.76	76,571.24	86.4%
210203	ҮОМШӨ-ний даатгал	451,400.00	390,924.80	60,475.20	86.6%
210204	Ажилгүйдлийн даатгал	112,900.00	96,051.96	16,848.04	85.1%
210205	Эрүүл мэндийн даатгал	1,128,600.00	978,205.52	150,394.48	86.7%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,797,700.00	30,158,000.00	639,700.00	97.9%
210301	Гэрэл, цахилгаан	539,700.00	00.00	539,700.00	
210302	Түлш, халаалт	30,158,000.00	30,158,000.00	0.00	100.0%
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	00.00	100,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	937,800.00	904,000.00	33,800.00	96.4%
210401	Бичиг хэрэг	204,000.00	203,900.00	100.00	100.0%
210402	Тээвэр, шатахуун	337,800.00	333,500.00	4,300.00	98.7%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,200.00	171,600.00	28,600.00	85.7%
210404	Ном, хэвлэл	50,000.00	50,000.00	0.00	100.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	145,800.00	145,000.00	800.00	99.5%
2105	Нормативт зардал	100,000.00	00.00	100,000.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	00.00	100,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,003,000.00	937,900.00	65,100.00	93.5%
210601	Багаж, техник, хэрэгсэл	131,000.00	69,900.00	61,100.00	53.4%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	83,300.00	80,000.00	3,300.00	96.0%
210604	Урсгал засвар	788,700.00	788,000.00	700.00	99.9%
2107	Томилолт, зочны зардал	133,500.00	100,000.00	33,500.00	74.5%
210702	Дотоод албан томилолт	133,500.00	100,000.00	33,500.00	74.5%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,740,000.00	1,675,500.00	64,500.00	96.3%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,524,000.00	1,459,500.00	64,500.00	95.8%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	216,000.00	0.00	100.0%

Сагил сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00	0.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00	0.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00	0.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17332400.00	17282400.00	50,000.00	99.7%
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00	0.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,332,400.00	17,282,400.00	50,000.00	99.7%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,082,400.00	17,082,400.00	0.00	100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	250,000.00	200,000.00	50,000.00	80.0%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	00.00	0.00	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	116,089,800.00	105,447,262.85	10,642,537.15	90.8%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	116,089,800.00	105,447,262.85	10,642,537.15	90.8%
132001	Орон нутгийн төсвөөс	116,089,800.00	105,447,262.85	10,642,537.15	90.8%
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих				
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00		
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	06.00	06.00		
620001	Удирдах ажилтан	01.00	01.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	03.00	03.00		
620003	Үйлчлэх ажилтан	01.00	01.00		
620004	Гэрээт ажилтан	01.00	01.00		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сагил сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Амармэнд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Сагил сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сагил сумын Соёлын төв нь төрөөс соёлын талаар баримтлах бодлого, ардын урлаг, үндэсний хөтөлбөрүүд, түүх соёлын дурсгалын зүйл, өвийг хадгалж хамгаалах, төр олон нийт ард иргэд, залуус өсвөр үеийнхний соёл хүмүүжил, оюуны болон чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, авьяас билэг, ур чадварыг нээн илрүүлэх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд аймгийн Орон нутгийн өмчийн газраас орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн талаар хяналт мониторинг хийсэн байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сагил сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 967.7 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 144.199.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,441.9 мянган төгрөгийн 80 хувиар буюу 1,153.5 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гарах цагалбарт хугацаа болоогүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сагил сумын Соёлын төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 28,250.2 мянган төгрөгөөр буюу 4.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт Б	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	76.7	33.3	-43.8
Бараа материал	7,603.3	8,816.7	1,213.4
Үндсэн хөрөнгө	668,099.4	638,679.1	-29,420.3
Нийт хөрөнгө	675,779.4	647,529.2	-28,250.2
Өр төлбөр	0.0	66.2	-66.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	675,779.4	647,462.9	-28,316.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	675,779.4	647,529.2	-28,316.5

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 8,816.7 мянган төгрөг болж 1,213.4 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэрэг, аж ахуйн материал байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 638,679.1 мянган төгрөг болж 29,420.3 мянган төгрөгөөр буурсан нь 16,483.5 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 8,028.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 7,676.2 мянган төгрөгийн тавилга хэрэгслийн үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 647,462.9 мянган төгрөг болж 28,316.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 45,990.6 мянган төгрөгөөр буюу 60 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 18,372.3 мянган төгрөгөөр буюу 8.3 хувиар өссөн байна. Үүнд байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, томилолтын зардал, хангамжийн бараа материалын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлууд байна.

Тайлант онд 32.8 мянган төгрөгийн газрын төлбөрийн өр үүссэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга 1,790.1 мянган төгрөгөөр хийгдсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Сагил сумын Соёлын төвийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 116,089.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 116,089.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг ирүүлсэн санал болох 116,089.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 116,089.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 116,089.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 105,447.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 105,447.2 мянган төгрөгийг зарцуулж, 10,642.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 105,447.2 мянган төгрөг буюу 90.8 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар орлого зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Сагил сумын Соёлын төвийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 124, хугацаа хоцорсон 25, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Г.АМАРМЭНД/

2022 оны 02 сарын 21-ний өдөр